



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2016 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Жи Эс Би Капитал ББСБ” ХХК-ийн хувьцаа  
эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг  
зөвшөөрөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, Хорооны 2015 оны 409 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 9.1.1, 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Жи Эс Би Капитал ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Ц.Алимаа нь өөрийн эзэмшлийн нийт 6,450,000,000.00 /зургаан тэрбум дөрвөн зуун тавин сая/ төгрөгийн үнэ бүхий 6,450 /зургаан мянга дөрвөн зуун тавин/ ширхэг, 100 хувийн хувьцааг “Шунхлай групп” ХХК-д бэлэглэлийн гэрээний дагуу шилжүүлсэн тул хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнийг энэ тушаалын хавсралтад заасны дагуу өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлэн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, хувийг Хороонд ирүүлэхийг “Жи Эс Би Капитал ББСБ” ХХК /Ч.Чинбат/-д үүрэг болгосугай.

3. Тушаалыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.


ДАРГА



З.НАРАНТУЯА

001769

Хорооны даргын 2016 оны 01 дүгээр  
сарын 07-ны өдрийн 01 тоот  
тушаалын хавсралт



**“Жи Эс Би Капитал ББСБ” ХХК-ийн хувьцаа  
эзэмшигчдийн бүрэлдэхүүнд оруулах өөрчлөлт**

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс /регистрийн дугаар/	Дүрмийн сангийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	Ц.Алимаа /ХБ65062781/	6,450,000,000.00	(6,450,000,000.00)	0.00	0.0 %
2	“Шунхлай групп” ХХК /2737779/	0.00	6,450,000,000.00	6,450,000,000.00	100.0%
	Дүн	6,450,000,000.00	6,450,000,000.00	6,450,000,000.00	100.0%

-0-0-0-0-0-0-0-